

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 сарын 28

дугаар 01

Шарын гол сум

Компанийн жилийн үйл ажиллагааны болон
Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн
удирдах зөвлөлийн дүгнэлтийн тухай

“Шарын гол” хувьцаат компанийн 2024 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд,

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Шарын гол” хувьцаат компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБААТАР

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 сарын 28

дугаар 02

Шарын гол сум

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны цалин урамшуулал, зардлын төсөв
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны цалин урамшуулал, зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБААТАР

2025 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын 02 дугаартай тогтоолын Хавсралт



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв

д/д	Зардлын төрөл	НИЙТ ЗАРДАЛ төгрөгөөр
1	ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин	164,700,000
2	Нийгмийн даатгалын шимтгэл	23,881,500
3	Холбоо	556,655
4	Албан журмын даатгал	2,188,845
5	АТБӨЯХ-ийн албан татвар	98,709
6	Түлш	5,126,148
	Нийт	196,551,857

---o0o---

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025.04.28

дугаар 03

Шарын гол сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, компанийн дүрмийн 8.3 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд

Б.Батбаатар
Б.Дөлгөөнтамир
Н.Батнайрамдал
Б.Мэндсайхан
Б.Гэрэлтуяа
Б.Тулга

Хараат бус гишүүнд

Г.Хулан
Б.Итгэл
Ж.Эрдэнэбат

нарыг

2025 оны 4 дүгээр сарын 28-ний өдрөөс 2027 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 2 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБААТАР